

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага (байршил, өмчийн хэлбэр, ангилал)


Монгол Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1,439 хүүхдийн цэцэрлэг¹ үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 910 цэцэрлэг (27 төмөр замын харьяа хүүхдийн цэцэрлэг), хувийн 529 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 4 цэцэрлэг (төрийн 21 нэмэгдэж, хувийн 17 хасагдсан) нэмэгдсэн байна.

График 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага (он, өмчийн хэлбэрээр)



Сүүлийн 5 жилийн байдлаар нийт цэцэрлэгийн жилийн дундаж өсөлт 2.1, төрийн өмчийн цэцэрлэгийн жилийн дундаж өсөлт 1.8, хувийн цэцэрлэгийн жилийн дундаж өсөлт 2.5 хувьтай байна.

График 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага (он, байршлаар)



Сүүлийн 5 жилийн байдлаар хотод байршилтай цэцэрлэгийн жилийн дундаж өсөлт 3.2, орон нутгийн цэцэрлэгийн жилийн дундаж өсөлт 1.1 хувьтай байна.

Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага (тоогоор)

Хичээлийн жил	Цэцэрлэгийн тоо	Байршил	
		Хот	Хөдөө
2015-2016	1,288	564	724
2016-2017	1,354	623	731
2017-2018	1,416	661	755

¹ "Хүүхдийн цэцэрлэг" гэж 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг ойлгоно.

2018-2019	1,435	682	753
2019-2020	1,439	685	754

Хувийн цэцэрлэгийн 434 буюу 82.0 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Улаанбаатар хотын хувийн цэцэрлэг өмнөх оноос 7-оор хасагдсан байна.

Нийт цэцэрлэгийн 47.6 хувь нь нийслэл Улаанбаатар хотод ногдож байгаа бөгөөд өмнөх оноос 0.1 пунктээр өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлгийн тоо

2019-2020 оны хичээлийн жилд 8,122 бүлэг хичээллэж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 219 буюу 2.7 хувиар нэмэгдсэн. (Хүснэгт 2). Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт² дунджаар 32.4 байгаа нь өмнөх жилээс 0.7-оор буурсан байна. Цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 32.6-тай байгаа нь өмнөх оноос 0.8-аар буурсан байна. Төрийн цэцэрлэгт үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 34.9 байгаа бол хувийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 23.0-тай байна.

Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг (тоогоор)

Хичээлийн жил	Бүлгийн тоо	Үүнээс:		Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2015-2016	7,033	6,150	883	5,655	4,783	872	1,378	1,367	11
2016-2017	7,492	6,637	855	5,908	5,055	853	1,584	1,582	2
2017-2018	7,808	6,981	827	6,125	5,300	825	1,683	1,681	2
2018-2019	7,903	7,177	726	6,166	5,441	725	1,737	1,736	1
2019-2020	8,122	7,445	677	6,451	5,774	677	1,671	1,671	-

Улаанбаатар хотын үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 35.2 бөгөөд өмнөх оноос 0.5-аар, хувийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 23.0 буюу өмнөх оноос 1.1-аар тус тус өссөн бол төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 35.4 байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн тоо

Сургуулийн өмнөх боловсролын салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 263,333 хүүхэд хамрагдаж байгаагаас 242,623 буюу 92.1 хувь нь цэцэрлэгийн өдрийн, 24 цагийн үйл ажиллагаатай³ болон энгийн сургалтад, 20,710 буюу 7.9 хувь нь хувилбарт сургалт⁴-д хамрагдаж байна.

Хүүхэд харах үйлчилгээнд 2,130 хүүхэд хамрагдаж байна.

² “Бүлэг дүүргэлт” нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.

³ “24 цагийн ажиллагаатай” гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагын хамтрасан шийдвэрээр ажлын 5 өдөр тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг болон бүлгийг хэлнэ.

⁴ “Хувилбарт сургалт” үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгааг хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

График 3. СӨБ-д хамрагдагчид (Сургалтын хэлбэр, оноор)



Цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдаж байгаа хүүхдийг бүлгээр нь авч үзвэл: бага бүлэгт 45,372 буюу 18.7 хувь, дунд бүлэгт 55,672 буюу 22.9 хувь, ахлах бүлэгт 65,414 буюу 27.0 хувь, бэлтгэл бүлэгт 70,847 буюу 29.2 хувь, холимог бүлэгт 5,3182 буюу 2.2 хувь нь хамрагдаж байна.

Хувилбарт сургалтад 20,710 буюу 7.9 хувь нь хамрагдаж байгаа нь өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна. Үүнээс 3,212 хүүхэд ээлжийн бүлэгт⁵, 15,045 хүүхэд нүүдлийн бүлэгт⁶, 2,453 хүүхэд явуулын багшийн⁷ үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг эзэмшиж байна.

Хүснэгт 3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхэд (тоогоор)

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс:		Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2015-2016	225,388	201,834	23,554	196,639	173,273	23,366	28,749	28,561	188
2016-2017	243,432	219,811	23,621	209,568	185,972	23,596	33,864	33,839	25
2017-2018	256,720	233,015	23,705	220,049	196,371	23,678	36,671	36,644	27
2018-2019	261,354	239,764	21,590	222,150	200,579	21,574	39,204	39,185	16
2019-2020	263,333	242,623	20,710	224,975	204,265	20,710	38,358	38,358	-

Сүүлийн 5 жилээр харьцуулахад сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн жилд дунджаар 2.9 пунктээр өссөн байна. Үндсэн сургалтад хамрагдсан хүүхдийн тоо 2,859-өөр нэмэгдсэн байна.

Өмчийн хэлбэрээр авч үзвэл нийт хамрагдаж байгаа хүүхдийн 85.4 хувь нь төрийн өмчийн, 14.6 хувь нь хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.

Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 90.8 хувь нь үндсэн сургалтад, 9.2 хувь нь хувилбарт сургалтад хамрагдаж байгаа бол хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж бүх хүүхэд үндсэн сургалтад хамрагдаж байна.

⁵ “Ээлжийн бүлгийн сургалт” боловсролын стандартыг баримтлан танхимын хэлбэрээр хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

⁶ “Нүүдлийн бүлгийн сургалт” боловсролын стандартыг баримтлан гэр бүл, хүүхдэд үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

⁷ “Явуулын багшийн сургалт” боловсролын стандартыг баримтлан гэр бүлд түшиглэж, хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

Хүснэгт 6. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс								
		Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Оюуны	Аутизм	Дауны хам шинж	Хавсарсан
2015-2016	1,369	218	252	81	390	-	151	-	-	277
2016-2017	1,513	241	282	102	451	-	170	-	-	267
2017-2018	1,599	274	261	97	391	-	198	-	-	378
2018-2019⁸	1,087	110	106	54	270	47	27	93	38	342
2019-2020	1,076	93	96	60	290	33	42	111	69	282

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 827 буюу 76.9 хувь нь төрөлхийн, 249 буюу 23.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.

Энэ хичээлийн жилд нийт хүүхдийн 106,892 буюу 40.6 хувь нь цэцэрлэгт шинээр элсэн орсон бөгөөд өмнөх оноос 2,894 хүүхэд буюу 2.7 хувиар өссөн байна.

Ажиллагчид болон багшлах боловсон хүчин

2019-2020 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 28,070 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 8,068 буюу 28.7 хувийг үндсэн багш нар эзэлж байгаа нь өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна. Нийт багш, ажиллагчдын тоо өмнөх оноос 856-аар буюу 3.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагчид

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Үүнээс		Төрийн өмч	
		Төрийн өмч	Хувийн өмч	Хот	Хөдөө
2015-2016	24,179	20,004	4,175	6,698	13,306
2016-2017	25,639	21,085	4,554	7,341	13,744
2017-2018	27,172	22,314	4,858	8,084	14,230
2018-2019	27,214	22,292	4,922	8,199	14,104
2019-2020	28,070	23,489	4,581	8,927	14,562

2019-2020 оны хичээлийн жилд нийт ажиллагчдын 12,617 буюу 44.9 хувь нь хотод, 15,453 буюу 55.1 хувь нь хөдөө, орон нутагт ажиллаж байна. Төрийн өмчийн байгууллагад ажиллагчдын 38.0 хувь хотод, 62.0 хувь нь хөдөө, орон нутагт ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багш өмнөх жилээс 2.8 хувиар өссөн байна.

⁸ ҮСХ-ны даргын 2017.12.19-ны А/207, БСШУСС-ын 2018.01.05-ны А/009 тушаалаар үзүүлэлт нэмэгдсэн.

Хүснэгт 8. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн болон туслах багш

Хичээлийн жил	Үндсэн багш	Үүнээс:							Туслах багш
		Бүлгийн	Дуу хөгжмийн	Биеийн тамирын	Тусгай мэргэжлийн	Ээлжийн бүлгийн	Нүүдлийн	Явуулын	
2015-2016	6,833	6,052	639			65		77	6,133
2016-2017	7,302	6,520	657			64		61	6,508
2017-2018	7,745	6,892	741			64		48	6,970
2018-2019 ⁹	7,843	6,929	663	159	7	33	21	31	6,673
2019-2020	8,068	7,102	709	189	-	20	25	23	6,870

Мөн ээлжийн багш 33, сэргээн засалч 19, нийгмийн ажилтан 5 ажиллаж байна.

Хүснэгт 9. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн хангалт	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2015-2016	94.8	1	442	4,922	1,112	356
2016-2017	95.7	-	499	5,505	986	114
2017-2018	97.3	-	540	6,097	899	209
2018-2019	91.7	-	532	6,008	650	653
2019-2020	91.1	-	549	6,182	621	716

2019-2020 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн 2,149 буюу 26.6 хувь нь 29 хүртэл, 2,640 буюу 32.7 хувь нь 30-39, 2,302 буюу 28.5 хувь нь 40-49, 894 буюу 11.1 хувь нь 50-59, 83 буюу 1.0 хувь нь 60-аас дээш настай байна.

Хүснэгт 10. Багш нарын нас (насны ангиллаар)

	29 хүртэл	30-39	40-49	50-59	60 ба түүнээс дээш
2015-2016	2,047	2,039	2,103	604	40
2016-2017	2,192	2,205	2,219	629	57
2017-2018	2,285	2,409	2,292	683	76
2018-2019	2,209	2,464	2,291	803	76
2019-2020	2,149	2,640	2,302	894	83

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 91.1 хувь болсон нь өмнөх оноос 0.6 пунктээр буурсан байна.

Нийт үндсэн багшийн 2,097 буюу 26 хувь нь мэргэжлийн зэрэгтэй бөгөөд үүнээс 5 зөвлөх, 387 тэргүүлэх, 1705 багш заах аргач зэрэгтэй байна.

-----000-----

⁹ ҮСХ-ны даргын 2017.12.19-ны А/207, БСШУСС-ын 2018.01.05-ны А/009 тушаалаар үзүүлэлт нэмэгдсэн.